



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 15/03

Сайншанд сум

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны  
“Хөгжлийн төлөө хамтдаа-2” хөтөлбөрийн  
2023 оны биелэлтийг үнэлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 дугаар тогтоолоор батлагдсан Дорноговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилт, түүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэн биелэлтийг 93,6 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2.Тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хүргэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гаргасан санал, дүгнэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нутгийн удирдлагын хөгжлийн хорооны ахлагч (И.Батсүрэн), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ

442230127